



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



СУУРЬ БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ЭРҮҮЛ МЭНД

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

ЭРҮҮЛ МЭНД

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|----------------------------|---|
| Суралцагчийн үнэлгээ | 2 |
|----------------------------|---|

СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

| | |
|---|----|
| Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж | 5 |
| Хоёр. Нэгж үнэлгээний жишиг даалгавар | 9 |
| 2.1. Сонгох даалгаврын жишээ, аргачлал | 9 |
| 2.2. Задгай даалгаврын жишээ, аргачлал | 11 |
| Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал | 15 |

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

Эрүүл мэнд хичээлийн хувьд суралцахуйн удирдамжид тусгасан үндсэн 6 чиглэл буюу бүлэг сэдвийг нэгж болгон авсан. Тиймээс үнэлгээний нэгж нь бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин дэх бүх ангид ижил байна. Энэ нь боловсролын түвшин тус бүрт сурагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг тэдгээр нэгж бүрээр үнэлж, үр дүнг тооцох давуу талыг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл, үнэлгээний нэгжийг ашиглан хөндлөн болон босоо байдлаар үнэлгээг хийх бүрэн боломжтой юм. Эдгээр 6 нэгж тус бүрээр сурагчийн ахиц дэвшлийг анги тус бүрт төдийгүй боловсролын түвшин тус бүрт сурагчид өөрсдөө болон хөндлөнгөөс үнэлж, үр дүнг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийж болно.

Суралцахуйн үр дүн нь бидний хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал юм. Тиймээс суралцахуйн үр дүнг боловсруулахдаа зөрүүг нөхөх зарчмыг баримталсан болно. Тус зарчимд тулгуурлан дараах алхмын дагуу тунгаан бодож суралцахуйн үр дүнг томьёолсон. Үүнд:

- Одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлыг тодорхойлох
- Одоогийн болон хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлын хооронд ямар зөрүү байгааг олж илрүүлэх
- Мэдлэг, чадвар, хандлагатай холбоотой ямар зүйлийг суралцах шаардлагатай байгааг тодорхойлох
- Тус зөрүү буюу дутуу зүйлийг хэрхэн нөхөхийг тодорхойлох

Нэгж тус бүрийн хүрээнд одоогийн нөхцөл байдлыг бодит мэдээ баримт, тулгамдсан асуудалд үндэслэн тодорхойлсон. Тухайлбал, сэтгэцийн эрүүл мэнд нэгжийн хүрээнд хүүхэд өсвөр үеийнхэнд нас, сэтгэл зүйн онцлогтой холбоотой ямар асуудлууд нийтлэг тулгамддаг талаарх бодит мэдээ баримтыг ашиглан одоогийн нөхцөл байдлыг төсөөлөн тодорхойлсон.

Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал нь одоогийн нөхцөл байдал шийдвэрлэгдсэн байх тэр цаг мөч бөгөөд энэ нь ямар байдлаар шийдвэрлэгдсэн байхыг томьёолсон томьёоллыг хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал гэж үзэж болно.

Одоогийн болон хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлыг тодорхойлсны дараа эдгээрийн хооронд ямар зөрүү байгааг илрүүлнэ. Үүний тулд одоогийн нөхцөл байдлаас хүсэж буй нөхцөл байдалд хүрэхэд юу дутаад байгааг олж тогтооно. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр нөхцөл байдлын зөрүүг үүсгэж буй шалтгааныг тодорхойлно.

Ийнхүү тус шалтгаан бүхий зөрүүг олж илрүүлэн, түүнийг хэрхэн нөхөхийг томъёолсон томъёолол нь суралцахуйн үр дүн болно. Энэ нь сурагчдын эрүүл мэндийн боловсролын хэрэгцээтэй нягт уялдаатай юм.

Зөрүү нөхөгдөж, өөрчлөлт гарсан эсэхийг буюу хүссэн үр дүндээ хүрсэн эсэхийг тодорхойлж буй байдал нь үнэлгээ юм. Тус өөрчлөлтийг хэрхэн хэмжихийг илэрхийлж буй зүйл нь үнэлгээний арга юм.

Сэтгэцийн эрүүл мэнд нэгжийн хүрээнд суралцахуйн үр дүнг боловсруулахдаа дээрх зөрүүг нөхөх зарчмыг баримталсан болно.

Дээрх зүйлийг жишээний хамтаар дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 1.

| Одоогийн нөхцөл байдал | Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал | Илэрсэн зөрүү | Мэдлэг, чадвар, хандлагын улмаас үүссэн зөрүү | Суралцахуйн үр дүн |
|---|---|---|--|---|
| Одоо юу болж байна вэ? /одоо ямар байна вэ? | Юу болох ёстой вэ? / ямар байх ёстой вэ? | Ямар байгаа болон ямар байх ёстой хоёрын зөрүү, ялгаа нь юу вэ? | Та одоогийн нөхцөл байдлыг ямар учраас байгаа гэж боддог вэ? | Хичээлийн үйл ажиллагаанд оролцсоны үр дүнд сурагчид юу чаддаг болсон байхыг та хүсэж байна вэ? |
| Өсвөр насныхан өөртөө итгэлтэй харилцаж чадахгүй байна | Өсвөр насныхан өөртөө итгэлтэй харилцдаг байх | Тэд харилцааны хэлбэр, тэдгээрийн үр нөлөө, хэрхэн өөртөө итгэлтэй харилцах аргыг мэддэггүй | М: өөртөө итгэлтэй харилцахад юуг анхаарах хэрэгтэйг мэдэхгүй Ч: үгэн ба үгэн бус хэлбэрийг оновчтой хослуулан ашиглаж чадахгүй Х: өөртөө итгэлтэй харилцааны ач холбогдлыг ухаараагүй | Сурагч ямар ч нөхцөлд бусадтай үгэн ба үгэн бус хэлбэрийг оновчтой хослуулан өөртөө итгэлтэй харилцдаг болно. |
| Өсвөр насныхан бусдад анхаарал, халамж тавьж байгаагаа үг, үйлдлээр оновчтой илэрхийлж сураагүй | Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үгээр болон үйлдлээр оновчтой илэрхийлдэг байх | Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үгээр болон үйлдлээр хэрхэн оновчтой илэрхийлэхийг мэддэггүй | М: бусдад ямар арга замаар анхаарал халамж тавихаа мэддэггүй Ч: анхаарал халамж тавьж буйг илэрхийлэх үг, үйлдлийг оновчтой сонгож хэрэглэдэггүй Х: бусдад анхаарал халамж тавихыг боддоггүй | Сурагч янз бүрийн нөхцөлд бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үг, үйлдлээрээ оновчтой харуулдаг болно. |

Үнэлгээний шалгуурыг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

- ✓ Нэгж хичээлийг судалснаар сурагчдад бодитой ямар өөрчлөлт гарахыг тооцоолох
- ✓ Багш тухайн өөрчлөлтийг хэрхэн үнэлэхээ тодорхойлох
- ✓ Бодит чадварын үнэлгээг орхигдуулахгүй байхад анхаарах
- ✓ Агуулга, үйл явц, чанар, үр нөлөөг үнэлэхэд чиглэгдсэн байх

Гүйцэтгэлийн 4 түвшинг боловсруулахдаа дараах зарчимд тулгуурласан. Үүнд:

- ✓ Гүйцэтгэлийн түвшин тус бүр нь сурагчдын бодит байдлыг үнэлэх боломжтой байх ба оноожуулах боломжтой байх
- ✓ Цогц байх буюу гүйцэтгэлийн чанарын талаар дүгнэлт хийх боломжтой байх
- ✓ Үнэлгээний шалгуурт суурилсан байх буюу түүний цар хүрээнээс хэтрэхгүй байх

Бид суурь боловсролын түвшинд 7 дугаар ангийн “Сэтгэцийн эрүүл мэнд” нэгжийг сонгон авч, тус нэгжийн хүрээнд үнэлгээг хэрхэн хийх талаар энэхүү зөвлөмждөө тусгасан. Үнэлгээний даалгаврыг боловсруулахдаа дараах үзэл баримтлалыг мөрдлөгө болгосон.

Үнэлгээний гол зорилго бол сурагчдын ахиц дэвшил, хөгжлийг дэмжихэд оршино. Үнэлгээ нь сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг зөвхөн үнэлэх төдий зүйл бус харин суралцагчид хэрхэн суралцаж байгааг илрүүлэх, суралцах үйл ажиллагааг хэрхэн өрнүүлэхийг шийдвэрлэх, сурагч цаашид хэрхэн суралцах стратегийг сонгох, түүнчлэн сургалтын агуулга ба сургалтын заах арга зүйг сайжруулах, сургалтад ашиглах хэрэглэгдэхүүнийг баяжуулахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, сурагчийн сурах үйл явц болон багшийн сургах үйл явцыг сайжруулахад ашиглагдана. Тиймээс багш нар үнэлгээ хийхдээ дээрх зорилгыг санаж байх нь чухал юм.

Боловсролын салбарын практик үйл ажиллагааны хүрээнд гарааны, явцын болон үр дүнгийн үнэлгээг хэрэглэдэг. Гарааны үнэлгээ нь тухайн хичээлийг зааж эхлэхийн өмнө сурагчийн мэдлэг, чадвар, хандлага ямар байгааг илрүүлэх ба тус үнэлгээний үр дүнг явцын болон эцсийн үнэлгээтэй харьцуулан сурагчийн ахиц дэвшлийг тодорхойлоход ашиглана.

Явцын үнэлгээ нь сурагч хичээлийн явцад хэрхэн суралцаж байгааг илрүүлэх ба энэ нь багш, сурагчийн хувьд дараах шийдвэр гаргахад хэрэглэгдэнэ. Үүнд:

- ✓ Сурагчийн хувьд цаашид хэрхэн суралцах арга замаа тодорхойлох
- ✓ Багш нарын хувьд сурагчдын суралцах үйл явцыг хэрхэн өрнүүлэх, сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг хэрхэн сайжруулах талаар шийдвэр гаргах

Үр дүнгийн үнэлгээг тухайн хичээлийн жилийн эцэст хийх бөгөөд энэ нь дараах зорилгыг хангахад чиглэгдэнэ. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн хичээлийг судалж дууссаны дараа сурагч тус бүр юу мэддэг, чаддаг болж, ямар итгэл үнэмшил, хандлагатай болсныг тодорхойлохын зэрэгцээ сурагчдад тухайн хичээлийг ямар түвшинд судалсныг харуулах дүн тавина.
- ✓ Тухайн сургалтын хөтөлбөрийн зорилго хэр зэрэг биелэгдсэн, үр дүндээ хэр хэмжээгээр хүрснийг дүгнэнэ. Тус үнэлгээ дүгнэлтийг сурагчийн өвөрмөц ялгаатай бүлгээр, нэг сургуулийн эрүүл мэндийн хичээл зааж буй багш тус бүрээр, мөн сургууль, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын хэмжээнд гэх зэргээр хийж судлан шинжлэх ба улмаар бодлогын шийдвэр гаргахад ч ашиглах боломжтой.

Бид энэхүү зөвлөмждөө эрүүл мэнд хичээлийн үр дүнг хэрхэн үнэлэх, тус үнэлгээнд үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүнийг хэрхэн ашиглах талаар тусгасан болно. Үүнийг өөрсдийн үйл ажиллагаандаа тусган авч, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тус зөвлөмжид тусгагдсан нэр томъёо болон үндсэн ухагдахууныг ямар утга агуулгаар хэрэглэсэн болохыг мэдэх хэрэгтэй. Энэ хэсэгт бид дараах нэр томъёог тайлбарлах болно.

Тус зөвлөмжид хэрэглэгдэж буй нэр томъёоны тайлбар

Шалгуур: Энэ нь сурагчийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглах удирдамж бөгөөд ихэвчлэн харьцангуй жижиг агуулгын нэгжийг хамрах ба заавартай нягт холбоотой байдаг. Мөн сурагчийн хийсэн зүйлийг гүйцэтгэлийн хэмжүүрийн дагуу үнэлэх үнэлгээний рубрикийг боловсруулахад үндэс суурь болно.

Бодит чадварын үнэлгээ: Үндсэн мэдлэг, чадвараа зөв хэрэглэж ашиглаж байгаа эсэхийг харуулахуйц бодит амьдрал дээрх үйлдлийг хийж гүйцэтгүүлэх үнэлгээний хэлбэр. Бодит чадварын үнэлгээний шалгуур нь мэдлэг бүтээх, эрэл хайгуул хийх, хичээл сургалтын үйл ажиллагаанаас бусад нөхцөлд эзэмшсэн мэдлэг, чадвараа амжилттай ашиглаж хэрэглэх зэргийг багтаана.

Гүйцэтгэлийн стандарт: Тодорхой агуулга ба/эсвэл чадварын түвшинд өөрийн мэддэг чаддаг зүйлээ харуулахын тулд хүүхдийн хийх ёстой зүйлийг илэрхийлсэн тодорхойлолт

Нотолгоо буюу үнэлгээний шалгуурын дагуу үнэлгээ хийсэн баримт мэдээлэл

7 дугаар ангийн “Сэтгэцийн эрүүл мэнд” нэгжийн хүрээнд үнэлгээний шалгуур тус бүрээр дараах зүйлсийг бүрдүүлж, баримт нотолгоо болгон ашиглах боломжтой. Эдгээрээс бид заримыг нь ашигласан болно.

| | |
|---|---|
| <p>Үнэлгээний шалгуур 1: Өөртөө итгэлтэй харилцааг харилцааны бусад хэлбэрээс ялган тодорхойлж чаддаг</p> | <ul style="list-style-type: none"> • Бөглөсөн сорил ба сорилд үнэлгээ өгсөн баримтын хуудас • Дасгал ажлын хуудас, багшийн үнэлгээ өгсөн бүртгэл тэмдэглэл |
| <p>Үнэлгээний шалгуур 2: Өөртөө итгэлтэй харилцаж байгааг илэрхийлэх үг хэллэг, дохио зангаа, биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал, дуу хоолойны өнгийг оновчтой хослуулан хэрэглэдэг</p> | <ul style="list-style-type: none"> • Дүрийн тоглолт, түүнд үнэлгээ өгсөн хуудас • Ярилцлагын хуудас болон ярилцлагын тэмдэглэл, үнэлгээ өгсөн баримт |
| <p>Үнэлгээний шалгуур 3: Бусдад анхаарал халамж тавих үг хэллэг эсвэл үйлдлийг нөхцөлд нь тохируулан оновчтой хэрэглэдэг</p> | <ul style="list-style-type: none"> • Мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх асуулгын хуудас, түүнийг үнэлсэн рубрик • Эхлэх/ зогсоох/ үргэлжлүүлэх картын хуудас • Өөрийн үнэлгээний бөглөсөн хуудас ба түүнд оноо өгсөн багшийн бүртгэл |

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

2.1. СОНГОХ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ, АРГАЧЛАЛ

Үнэлгээний даалгавар 1. Сорил бөглөх

| | |
|--------------------------------|---|
| Үнэлгээний даалгаврын зорилго: | Өөртөө итгэлтэй харилцааг харилцааны бусад хэлбэрээс ялгаж, өөртөө итгэлтэй харилцааны ач холбогдлыг ухаарсан эсэхийг тодорхойлох |
| Үнэлгээний төрөл: | Явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой |
| Даалгаврын хэлбэр: | Сонгох |
| Нотлох баримт: | Сурагчийн бөглөсөн тестийн хуудас, үнэлгээ өгсөн хуудас |
| Гүйцэтгэх хугацаа: | 30 – 40 минут |

Дараах сорилыг сурагчдад тараан өгч бөглүүлнэ.

Сорилын хуудас

Сурагчийн нэр: _____ Он сар өдөр: _____

- Өгөгдлийг уншаад өөрийн хариултад харгалзах нүдэнд (+) тавина уу. (Зөв хариулсан өгөгдөл тус бүр - 1 оноо).

| № | Өгөгдөл | Тийм | Үгүй |
|----|---|------|------|
| 1. | Түрэмгий харилцдаг хүнд хүмүүс дургүй байдаг. | + | |
| 2. | Бусдыг үл хүндэтгэн, тулган шаардсан байдлаар харилцахыг өөртөө итгэлгүй харилцаа гэнэ. | | - |
| 3. | Харилцааг өөртөө итгэлтэй итгэлгүй гэсэн хоёр хэлбэрт хуваадаг. | | - |
| 4. | Өөртөө итгэлтэй харилцаа гэдэг нь бүдүүлэг зан авир гаргалгүй, өөртөө итгэлтэй, илэн далангүй, шударга шулуун харилцахыг хэлнэ. | + | |
| 5. | Түрэмгий харилцаа нь ихэвчлэн сөрөг үр дагавар дагуулдаг. | + | |
| 6. | Өөртөө итгэлгүй харилцаанаас ихэнхдээ хүнд ашиглагдсан, бусдад гомдсон сэтгэгдэл үлддэг. | + | |
| 7. | Үгээр болон үгэн бус хэлбэрээр илэрхийлж байгаа утга санаа хоорондоо нийцэхгүй тохиолдолд үгийн бус дохиог чухалчлан үзнэ. | + | |

Оноожуулалт: Өгөгдөл тус бүрээр үнэлж, зөв хариулсан бол 1 оноо өгөх ба авах ёстой нийт оноо 7 байна.

2. Харилцааны хэлбэр тус бүрийн үед илрэх шинж тэмдгүүдийг харгалзуулан доор өгөгдсөн хариултаас зөвийг сонгоно уу. (2 оноо)

| | | | |
|----|--------------------------|----|---|
| 1. | Өөртөө итгэлтэй харилцаа | А. | Хүнийг дээрэлхэх, айлган сүрдүүлэх |
| 2. | Өөртөө итгэлгүй харилцаа | Б. | Санаа алдах, уурлах, урвайх |
| 3. | Түрэмгий харилцаа | В. | Өөрийн хүсэж байгаа зүйл, өөрт төрж байгаа мэдрэмжийг хэлэх |

1. 1В 2А 3Б

2. 1А 2Б 3В

3. 1В 2Б 3А

3. Өгөгдлийг уншаад өөрт тохирох хариултыг сонгон, харгалзах үсгийг дугуйлна уу.

| № | Өгөгдөл | Байнга | Заримдаа | Огт үгүй |
|---|---|--------|----------|----------|
| 1 | Хүндрэл бэрхшээл үүсгэлгүй бусадтай багаар ажилладаг | а | б | в |
| 2 | Хүмүүс хүссэн зүйлээ хийлгэхийн тулд янз бүрээр ятгасан ч миний хүсэл сонирхолд нийцээгүй зүйлийг хийхгүй. | а | б | в |
| 3 | Бусадтай харилцахдаа бүх хүний хүсэлт, хэрэгцээг бүрэн гүйцэд сонсдог. | а | б | в |
| 4 | Хүмүүстэй харилцахдаа өөрийн бодол санаа, сэтгэгдлээ тодорхой хэлдэг. | а | б | в |
| 5 | Бусдын хэлж байгаа зүйлийг ойлгож байгаагаа үгээр болон үйлдлээрээ харуулдаг. | а | б | в |
| 6 | Өөрийн зорилго амжилтад хүрэхийн тулд бие биеэ дэмжсэн, эерэг уур амьсгал бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. | а | б | в |

Оноожуулалт: а – 2, б – 1, в – 0. Өгөгдөл тус бүрээр оноо өгч, нийлбэр оноог гаргана. Дээрх даалгаврын хувьд авах ёстой дээд оноо – 12.

4. Өгөгдөл тус бүрийг уншаад дараах зүйлийг ашиглан өөрийн үзэл бодлыг илэрхийлэх тоог дугуйлна уу.

| № | Өгөгдөл | Санал нийлнэ | Эргэлзэж байна | Санал нийлэхгүй |
|---|---|--------------|----------------|-----------------|
| 1 | Өөртөө итгэлтэй харилцсанаар өөрийн хүсэл сонирхлоо тодорхойлж, шууд илэрхийлж, өөрийгөө болон бусдыг гомдоохгүй. | а | б | в |
| 2 | Өөртөө итгэлгүй харилцсанаар бусдад ашиглагдсан сэтгэгдэл төрдөг. | а | б | в |
| 3 | Санаа бодлоо шууд илэрхийлэх чадваргүй, амиа хичээсэн, өөртөө итгэлгүй хүн бусадтай түрэмгий харилцдаг. | а | б | в |
| 4 | Бусдын хэлсэн зүйлийг зөв ойлгосон гэдэгтээ итгэлтэй байхын тулд эргэж нягтлан асуух нь маш чухал. | а | б | в |
| 5 | Айлган сүрдүүлэх, гутаан доромжлох, шалтгаан тоочих, гуйх замаар хүмүүс өөрийн хүссэн зүйлээ хийлгэхийг хүссэн ч хийхгүй. | а | б | в |

Оноожуулалт: а хариултыг сонговол 1 оноо өгнө. Өгөгдөл тус бүрээр оноо өгч, нийлбэр оноог гаргана. Тус даалгаврын хувьд авах ёстой дээд оноо – 5. Харин б болон в хариултыг сонгосон тохиолдолд оноо өгөхгүй.

5. Аль нь өөртөө итгэлтэй харилцааны шинж вэ? Өөрийн сонгосон хариултын өмнөх үсгийг дугуйлна уу. (1 оноо)

- А. Бусадтай хүндэтгэлгүй харьцдаг
- Б. Бусдын хэлж байгаа үгийг гүйцэд сонсдоггүй
- В. Бодож байгаагаа шууд хэлчихдэг.
- Г. Бусдад дарамт учруулдаг

6. Харилцааны дараах хэлбэрт хүргэдэг зүйлсийг оновчтой харгалзуулан, доор өгөгдсөн хариултаас зөвийг нь сонгоно уу. (2 оноо)

| | | | |
|----|------------------------------|----|-------------------------------------|
| 1. | Идэвхгүй харилцахад хүргэдэг | А. | Хэт их бардам байх |
| 2. | Түрэмгий харилцахад хүргэдэг | Б. | Бусдад таалагдах гэж санаа зовох |
| 3. | Идэвхтэй харилцахад хүргэдэг | В. | Бусдын хэрэгцээ сонголтыг хүндэтгэх |

1. 1Б 2А 3В

2. 1А 2Б 3В

3. 1В 2Б 3А

7. Түрэмгий харилцааны шинжүүдийг дугуйлна уу. (1 оноо)

А. Бусадтай хүндэтгэлтэй харьцдаг

Б. Бусдыг сүрдүүлж заналхийлдэг

В. Бусдын үгийг гүйцэд сонсдог

Г. Бодож байгаагаа төвөггүй хэлдэг

8. Эерэг утгатай буюу “Би өгүүлбэр”-ийн хувилбарыг сонгоно уу. (1 оноо)

А. Чи дандаа л өөрийгөө зөв гэж боддог.

Б. Миний хэлж байгаа зүйлийг сонсохгүй байдагт чинь би дургүй.

В. Чи миний хэлж байгаа юмыг хэзээ ч сонсдоггүй.

Г. Энэ чинь ёстой тэнэг санаа.

9. Бусдад анхаарал халамж тавихын ач холбогдол юу вэ? (1 оноо)

А. Бусдын хэрэгцээг үл хүндэлж байгаа хэрэг юм.

Б. Бусдаас хариу хайр халамж нэхдэг.

В. Бусдын хариу хүндэтгэл, хайр халамжийг хүлээдэг.

Г. Өөрийгөө хүндлүүлэхийн тулд хийж байгаа зүйл.

10. Анхаарал халамжийг үйлдлээр илэрхийлсэн хэлбэрийг олж сонгоно уу. (1 оноо)

А. Өвдсөн найз руугаа утасдаж биеийг нь асуух

Б. Ахмад хүмүүс зэмлэх

В. Багш болон хэн нэгэнтэй мэндлэх

Г. Ахмад болон настай хүнд туслах

Зөв хариулт: 2-3, 5-В, 6-1, 7-Б, 8-Б, 9-В, 10-Г

2.2. ЗАДГАЙ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ, АРГАЧЛАЛ

Үнэлгээний даалгавар 1. Нөхөх болон хариулж бичих даалгавар

| | |
|--------------------------------|--|
| Үнэлгээний даалгаврын зорилго: | Харилцааны хэлбэр болон харилцаанд нөлөөлөх зүйлс, бусдад анхаарал халамж тавих зэргийг тодорхойлж чадаж байгаа эсэхийг үнэлэх |
| Үнэлгээний төрөл: | Гарааны, явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой |
| Даалгаврын хэлбэр: | Задгай |
| Нотлох баримт: | Сурагчийн бөглөсөн тестийн хуудас, үнэлгээ өгсөн хуудас |
| Гүйцэтгэх хугацаа: | 30 – 40 минут |

1. Дараах мэдээллийг анхааралтай уншаад цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.

Бусдын эрх ашгийг хохироолгүй өөрийнхөө эрх ашгийг хамгаалж чаддаг, өөрийгөө болон бусдыг хүндэтгэдэг, бусдыг хүлээцтэй сонсож, өөрийгөө ойлгуулж чаддаг, аливаа асуудалд эерэг, байдлаар сэтгэл хөдлөлөө илэрхийлж чаддаг боловч бусдад дарамт учруулдаггүй байхыг харилцаа гэнэ. (1 оноо)

Зөв хариулт: (өөртөө итгэлтэй)

2. Харилцааны хэлбэрүүдийг нэрлэнэ үү. (1.5 оноо)

- A. _____
 Б. _____
 В. _____

Зөв хариулт: (өөртөө итгэлтэй, өөртөө итгэлгүй, түрэмгий)

Оноожуулалт: Бичсэн зөв хариулт бүрт 0.5 оноо өгнө. Харилцааны 3 хэлбэрийг зөв нэрлэж бичсэн бол нийт 1.5 оноо өгнө.

3. Харилцааг амжилттай ба амжилтгүй болгоход нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэж жагсаан бичээрэй. (4 оноо)

| Харилцааг амжилттай болгоход нөлөөлөх хүчин зүйлс | Харилцааг амжилтгүй болгоход нөлөөлөх хүчин зүйлс |
|--|--|
| <input type="checkbox"/> _____ <input type="checkbox"/> _____ <input type="checkbox"/> _____ <input type="checkbox"/> _____ | <input type="checkbox"/> _____ <input type="checkbox"/> _____ <input type="checkbox"/> _____ <input type="checkbox"/> _____ |

Оноожуулалт: Бичсэн зөв хариулт бүрт 0.5 оноо өгнө. Дээрх 2 зүйл тус бүрт 4-өөс доошгүй зөв хариулт бичсэн байх ба нийт 8 зөв хариулт бичсэн тохиолдолд 4 оноо өгнө.

4. Бусдад анхаарал тавьж байсан бол тэдгээр үгс болон үйлдлүүдээ нэрлэж бичээрэй.

| | |
|--|---|
| Найздаа хэлж байсан миний үгс: - _____ - _____ | Найз минь надад үзүүлж байсан үйлдлүүд: - _____ - _____ |
| Багшийн хэлж байсан үгс: - _____ - _____ | Өндөр настанд үзүүлж байсан үйлдлүүд: - _____ - _____ |

Оноожуулалт: Бичсэн зөв хариулт бүрт 0.5 оноо өгнө. Дээрх 4 чиглэл тус бүрт 2-оос доошгүй оновчтой хариулт бичсэн байх ба нийт 8 оновчтой хариулт бичсэн тохиолдолд 4 оноо өгнө.

5. Өөртөө итгэлгүй хүн үе тэнгийнхний шахалтад орохоор юу гэж боддог вэ? (2 оноо)

- A. Үүнийг хийхгүй бол тэд надад дургүй болно гэж бодох
 Б. _____
 В. _____
 Г. _____

Оноожуулалт: Бичсэн зөв хариулт бүрт 0.5 оноо өгнө. 4-өөс доошгүй оновчтой хариулт бичсэн байх ба нийт 4 оновчтой хариулт бичсэн тохиолдолд 2 оноо өгнө.

Үнэлгээний даалгавар 2. Дүрийн тоглолт ба үе тэнгийнхний үнэлгээ

| | |
|--------------------------------|--|
| Үнэлгээний даалгаврын зорилго: | Өөрийн санаа бодол, сэтгэгдлийг үг ярианаас өөрөөр илэрхийлэх арга замаар үгэн бус харилцаагаар харилцах чадварыг үнэлэх |
| Үнэлгээний төрөл: | Явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой |
| Даалгаврын хэлбэр: | Задгай |
| Нотлох баримт: | Сурагчийн бөглөсөн асуулт хариултын хуудас, түүнд үнэлгээ өгсөн багшийн бүртгэл |
| Гүйцэтгэх хугацаа: | 30-40 минут |

Үгэн бус харилцааны хэлбэрүүд сэдвийн хүрээнд дүрийн тоглолтын удирдамж:

Дүрийн тоглолтод дараах боловсруулсан нөхцөлийг ашиглаарай. Багш хүсвэл өөр нөхцөл боловсруулан ашиглах боломжтой.

Сурагчдыг хос хосоор нь болгож, доорх нөхцөлөөс нэг нэгийг, үнэлгээний хуудсын хамт өгнө. Сурагчид хүснэгтэд өгөгдсөн нөхцөлд хэрхэн харилцах дүрийн тоглолтыг үзүүлнэ.

Заавар: Сурагчид өөрт оногдсон нөхцөлд хэрхэн харилцахыг дүрийн тоглолтоор ээлжлэн үзүүлнэ.

- 1-р баганын өгүүлбэрийг ашиглахдаа 2-р баганад байгаа зааврын дагуу нэг өгүүлбэрийг 2 янзаар уншина.
- 3-р баганад тухайн нөхцөлд ашиглаж буй үгэн бус харилцааны хэлбэрийг тодорхойлсон болно.
- Сурагчид үнэлгээний хуудсын дагуу дүрийн тоглогчийн харилцааны ур чадварыг харилцан үнэлж, оноо өгнө.

Нөхцөл 1. Дараах нөхцөлд чи хэрхэн харилцах вэ? Дүрд тоглож харуулна уу.

| Та юу гэж хэлэх вэ? | Үүнийг та хэрхэн хэлэх вэ? | Ашиглаж буй үгэн бус харилцааны хэлбэр |
|---|---|--|
| Маш сайн байна. | 1. Сайхан инээнэ. 2. Огт хувиралгүй гөлийсөн байдалтай | Нүүрний хувирал; нүүрээрээ |
| Чиний бэрхшээл юунд байгааг чи өөрөө мэднэ шүү дээ. | 1. Гараа хөдөлгөлгүй 2. Нүүр рүү нь чичлэн | Дохио зангаа; гараараа |

Нөхцөл 2. Дараах нөхцөлд чи хэрхэн харилцах вэ? Дүрд тоглож харуулна уу.

| Та юу гэж хэлэх вэ? | Үүнийг та хэрхэн хэлэх вэ? | Ашиглаж буй үгэн бус харилцааны хэлбэр |
|---------------------|--|--|
| Би үгүй гэж хэлсэн | 1. Хэвийн хоолойгоор 2. Чанга хашгирч | Дууны чанга/сул; дуу хоолойгоороо |
| Наашаа хүрээд ир | 1. Хэвийн хоолойгоор 2. Уцаартайгаар дуугаа өндөрсгөн | Дууны өнгө; дуу хоолойгоороо |

Нөхцөл 3. Дараах нөхцөлд чи хэрхэн харилцах вэ? Дүрд тоглож харуулна уу.

| Та юу гэж хэлэх вэ? | Үүнийг та хэрхэн хэлэх вэ? | Ашиглаж буй үгэн бус харилцааны хэлбэр |
|------------------------------|---|--|
| Би мэдэхгүй ээ. | 1. Хэвийн зогсолт 2. Мөрөө хавчин | Биеийн байрлал; биеэрээ |
| Би та нартай уулзмаар байна. | 1. Тэднээс хэвийн зайд зогсоно. 2. Тэдэнд маш ойрхон зогсоно | Зай; орон зайн байрлалаараа |

Нөхцөл 4. Дараах нөхцөлд чи хэрхэн харилцах вэ? Дүрд тоглож харуулна уу.

| Та юу гэж хэлэх вэ? | Үүнийг та хэрхэн хэлэх вэ? | Ашиглаж буй үгэн бус харилцааны хэлбэр |
|---------------------|---|--|
| Уучлаарай. | 1. Мөрөн дээр нь зөөлөн хүрч 2. Хүчтэй түлхэн | Биед хүрэх; гараараа |
| За. Сонсож байна. | 1. Тэдэн рүү өөдөөс нь харан 2. Өөр юм хийнгээ | Анхаарал; харцаараа буюу нүдээрээ |

Дүрийн тоглолтыг үнэлэх үнэлгээний хуудас

Сурагчийн нэр: _____

Он сар өдөр: _____

Анги: _____

Үнэлгээ өгсөн сурагчийн нэр: _____

| Чадвар | Маш сайн (3) | Сайн (2) | Сайжруулах шаардлагатай (1) |
|--|--|--|--|
| Өгүүлбэрийн утгыг хувирган унших чадвар Оноо _____ | <input type="checkbox"/> Дуу хоолойны өнгө нь хэлж буй үгийнхээ утга санааг бүрэн илэрхийлсэн бол | <input type="checkbox"/> Дуу хоолойны өнгө нь хэлж буй үгийнхээ утга санааг илэрхийлсэн бол | <input type="checkbox"/> Дуу хоолойны өнгө нь хэлж буй үгийнхээ утга санааг бүрэн гүйцэд илэрхийлээгүй |
| Өгөгдсөн нөхцөлийн утгыг хувиргах чадвар Оноо _____ | <input type="checkbox"/> Өгүүлбэрийн утгыг биеийн хэлэмжээр гүйцэд сайн илэрхийлсэн бол | <input type="checkbox"/> Өгүүлбэрийн утгыг биеийн хэлэмжээр илэрхийлсэн бол | <input type="checkbox"/> Өгүүлбэрийн утгыг биеийн хэлэмжээр бүрэн гүйцэд илэрхийлээгүй |
| Хэр зэрэг жүжиглэн дүрд хувирах чадвар Оноо _____ | <input type="checkbox"/> Хэлж буй үг ба үйлдэлдээ бүрэн нийцсэн тохиромжтой дохио зангааг хэрэглэж маш сайн үзүүлсэн бол | <input type="checkbox"/> Хэлж байгаа үг ба үйлдэлдээ нийцсэн тохиромжтой дохио зангааг хэрэглэж үзүүлсэн бол | <input type="checkbox"/> Хэлж буй үг ба үйлдэлдээ тохиромжтой бус зөрсөн дохио зангааг хэрэглэж үзүүлсэн бол |
| Нийлбэр оноо _____ | | | |

Жич: Дээрх 3 шалгуур тус бүрээр 1-3-ын хооронд оноо өгөх ба нийт авах ёстой оноо 3-9 байна. Тус оноог дараах байдлаар түвшинчлэн үнэлнэ.

- 3-4 хангалтгүй
- 5-6 дунд зэрэг
- 7-9 хангалттай

Багшийн анхаарах зүйл: Дүрийн тоглолтоо үзүүлэхдээ бодит амьдрал дээр тус нөхцөлд хэрхэн хандахыг чин сэтгэлээсээ илэрхийлэн, тоглоом шоглоом болгохгүйгээр өгөгдсөн хугацаанд хийж гүйцэтгэхийг сурагчдад сануулна. Үнэлгээ хийхдээ өгсөн шалгуурын дагуу үнэн зөв, бодитой, шударга үнэлэхийг сануулна.

Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Тус нэгжийн хүрээнд нийт 29 асуулт бүхий сонгох даалгавар, 6 задгай даалгаврыг боловсруулсан. Эдгээрийг хэрхэн ашиглаж, дүн шинжилгээ хийх талаар авч үзье.

Сонгох болон задгай даалгавар нь “Сэтгэцийн эрүүл мэнд” агуулгын хүрээг бүхэлд нь хамарсан бөгөөд эдгээрийг явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглахад тохиромжтой юм.

Дүрийн тоглолт нь “Харилцааны үгэн ба үгэн бус хэлбэр”-ийг хэрхэн хослуулан оновчтой илэрхийлэх чадварыг үнэлэхэд чиглэгдсэн бөгөөд үнэлгээг үе тэнгийн сурагч эсвэл тухайн сурагч өөрөө хийх боломжтой. Эсвэл сурагчийн өөрийн болон үе тэнгийнхний үнэлгээний аль алийг нь хийж, хооронд нь харьцуулан дүн шинжилгээ хийж болно. Ингэснээр илүү бодит үнэлгээ болно. Дүрийн тоглолтод сурагч өөрөө болон үе тэнгийн сурагчийн өгсөн оноо, түүний үндэслэлийг асууж ярилцах замаар тухайн сурагч юуг ханалттай сайн хийж байна, ямар зүйлийг сайжруулах шаардлагатай гэдгээ мэдэж авна. Багш нийт сурагчдын түвшинг нэгтгэн дүгнэж, харилцааны энэхүү чадварыг сайн эзэмшихэд нь чиглэсэн нэмэлт дасгал ажил, даалгаврыг төлөвлөнө.

Ангийн ихэнх суралцагч үгэн ба үгэн бус хэлбэрийг хослуулан өөртөө итгэлтэй харилцах чадварыг тааруухан гүйцэтгэж байвал тухайн чадварыг эзэмшүүлэх өөр үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнийг багш бусдад халамж анхаарал тавьж байгаагаа үгээр болон үйлдлээр илэрхийлэх чадвартай хослуулж болно. Бодит амьдрал дээр өсвөр насныханд сургууль, олон нийтийн газар, найз нөхөд, үе тэнгийнхэн болон гэр бүлийн хүрээнд тохиолдох харилцааны болон бусдад халамж анхаарал тавих янз бүрийн нөхцөл өгч, тухайн сурагч 3-аас доошгүй өөр хоорондоо эрс ялгаатай нөхцөлд хэрхэн өөртөө итгэлтэй харилцаж байгааг үнэлэхэд чиглэгдсэн даалгавар боловсруулж ашиглавал зохино. Ганцхан нөхцөлд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг үнэлэх нь бодит үнэлгээ болж чадахгүй байх магадлалтай учраас үүнийг анхаарах хэрэгтэй.

Дээр өгсөн даалгавруудыг гарааны үнэлгээнд ашиглаж болох ба ингэснээр сурагчдын ерөнхий түвшинг мэдэж, хичээлийг хэрхэн төлөвлөх талаар тунгаан бодоход багшид тусална. Мөн гарааны үнэлгээг сурагч тус бүр өөрийн үнэлгээ байдлаар ашиглаж, тухайн бүлэг сэдвийг судлахад юуг сайн сурах шаардлагатай болохыг тодорхойлон, судалсны дараа сурагч түүнийгээ хангалттай сайн сурч эзэмшсэн эсэхдээ өөртөө дүн шинжилгээ хийх боломжтой. Өөрийн үнэлгээг дангаар нь дүн тавих үнэлгээ болгон ашиглах боломжгүй тул бусад үнэлгээтэй хамт хэрэглэж, дүн шинжилгээ хийх нь тохиромжтой. Сурагчийн өөрийн үнэлгээ бусад үнэлгээтэй хэр зэрэг нийцэж буйг багш харьцуулан дүн шинжилгээ хийх хэрэгтэй (Доор өгсөн хүснэгтээс харна уу).

Тус нэгжийн үнэлгээнд ашигласан үнэлгээний даалгаврын төрөл тус бүрээр авсан оноог ижил хэмжээст шилжүүлэн, дараах байдлаар нэгтгэн, сурагч тус бүрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж болно.

| Үнэлгээний даалгаврын төрөл | Гүйцэтгэлийн шалгуур 1 | Гүйцэтгэлийн шалгуур 2 | Гүйцэтгэлийн шалгуур 3 |
|-----------------------------|------------------------|------------------------|------------------------|
| Сорил | () | | () |
| Нөхөж бичих даалгавар | () | | () |
| Дүрийн тоглолт | | () | |
| | | | |
| | | | |
| Нийт оноо | () | () | () |
| Дундаж оноо | () | | |

Багш хичээлийн үр дүнг сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг танин мэдэхүйн эсвэл гүйцэтгэлийн түвшнээр нь харьцуулан задлан шинжлэх боломжтой.

| Үнэлгээний даалгаврын төрөл | Гүйцэтгэлийн түвшин 1 | Гүйцэтгэлийн түвшин 2 | Гүйцэтгэлийн түвшин 3 | Гүйцэтгэлийн түвшин 4 |
|-----------------------------|-----------------------|-----------------------|-----------------------|-----------------------|
| Сорил | | | | |
| Нөхөж бичих даалгавар | | | | |
| Дүрийн тоглолт | | | | |
| | | | | |
| | | | | |
| Нийт оноо | | | | |
| Дундаж оноо | | | | |

Багш дараах байдлаар тухайн нэгжийн хүрээнд сурагч тус бүр ямар түвшинд хүрснийг тэмдэглэж, дүн шинжилгээ хийж болно.

Сурагчийн нэр: _____ Хугацаа: _____

Дараах зүйл тус бүрээр тухайн сурагч ямар түвшинд байгааг 1-4 гэсэн тоогоор тодорхойлно уу.
4 – хангалттай сайн, 1 – хангалтгүй

Түвшин

- 1 Өөртөө итгэлтэй харилцааны 5-аас доошгүй шинжийг тодорхойлж, жагсаалт гаргаж чадна
- 2 Өөртөө итгэлтэй харилцахын ач холбогдлыг түрэмгий харилцааны сөрөг үр дагавартай зэрэгцүүлэн жишиж тайлбарлаж чадна
- 3 Үгэн ба үгэн бус хэлбэрийг хослуулан янз бүрийн нөхцөлд тохируулан оновчтой хэрэглэж чадна
- 4 Бусдад халамж анхаарал шаардлагатай 5-аас доошгүй нөхцөлийг нэрлэж чадна
- 5 Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үгээр оновчтой илэрхийлж чадна
- 6 Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үйлдлээр оновчтой илэрхийлж чадна

| |
|--|
| |
| |
| |
| |
| |
| |

Ерөнхий түвшин: _____

Нэгжийн ерөнхий үнэлгээг дээрх загварын дагуу сурагч тус бүрээр хийж, нэгдсэн үнэлгээг гарган дүн шинжилгээ хийж болно. Тус үнэлгээнд дүн шинжилгээ хийхдээ тухайн сурагч ямар зүйлийг хэр түвшинд гүйцэтгэж чадаж байгааг нэг бүрчлэн танилцуулж, тус сурагч юуг илүү сайн суралцах хэрэгтэй, тухайн зүйлээ хэрхэн сурах боломжтой талаар багш зөвлөн тусална. Ийм маягаар сурагч тус бүрээр түвшинг тодорхойлохын зэрэгцээ ангийн бүх сурагчдын түвшинг дараах байдлаар нэгтгэн дүн шинжилгээ хийж болно.

| № | Сурагчийн нэр | Өөртөө итгэлтэй харилцааны 5-аас доошгүй шинжийг тодорхойлж, жагсаалт гаргаж чадна | Өөртөө итгэлтэй харилцахын ач холбогдлыг түрэмгий харилцааны сөрөг үр дагавартай зэрэгцүүлэн жишиж тайлбарлаж чадна | Үгэн ба үгэн бус хэлбэрийг хослуулан янз бүрийн нөхцөлд тохируулан оновчтой хэрэглэж чадна | Бусдад халамж анхаарал шаардлагатай 5-аас доошгүй нөхцөлийг нэрлэж чадна | Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үгээр оновчтой илэрхийлж чадна | Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үйлдлээр оновчтой илэрхийлж чадна |
|----|---------------|--|---|--|--|---|--|
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |
| 9 | | | | | | | |
| 10 | | | | | | | |
| 11 | | | | | | | |
| 12 | | | | | | | |
| 13 | | | | | | | |
| 14 | | | | | | | |
| 15 | | | | | | | |

Тус нэгжийн хүрээнд сурагчдын эзэмшсэн байвал зохих 6 зүйлийг ангийн бүх сурагчдын хэдэн хувь нь ямар түвшинд эзэмшсэнийг тодорхойлж, дундаж утгыг гарган, дараах хүснэгтэд бичиж тэмдэглээд дүн шинжилгээ хийнэ.

| № | Тус нэгжийн хүрээнд сурагчдын эзэмшсэн байвал зохих зүйлс | Түвшин | | | | |
|---|---|--------|---|---|---|-------------|
| | | 4 | 3 | 2 | 1 | Дундаж утга |
| 1 | Өөртөө итгэлтэй харилцааны 5-аас доошгүй шинжийг тодорхойлж, жагсаалт гаргаж чадна | | | | | |
| 2 | Өөртөө итгэлтэй харилцахын ач холбогдлыг түрэмгий харилцааны сөрөг үр дагавартай зэрэгцүүлэн жишиж тайлбарлаж чадна | | | | | |
| 3 | Үгэн ба үгэн бус хэлбэрийг хослуулан янз бүрийн нөхцөлд тохируулан оновчтой хэрэглэж чадна | | | | | |
| 4 | Бусдад халамж анхаарал шаардлагатай 5-аас доошгүй нөхцөлийг нэрлэж чадна | | | | | |
| 5 | Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үгээр оновчтой илэрхийлж чадна | | | | | |
| 6 | Бусдад анхаарал халамж тавьж байгаагаа үйлдлээр оновчтой илэрхийлж чадна | | | | | |

Сурагч өөрийгөө ямар түвшинд байгаагаа мэдсэнээр хэрхэн суралцах, юуг анхаарах зэргээ тодорхойлох боломж бүрдэнэ. Харин багшийн зүгээс ямар зүйлийг сурагчид сайн суралцсан, ямар зүйлийг дахин заах шаардлагатай, эсвэл арга зүйгээ өөрчлөх шаардлагатай болохыг мэдэх боломжтой юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Антони Ж.Нитко., Сюзан М.Брүүкхарт, 2011. Суралцагчдын эзэмшсэн боловсролыг үнэлэх арга зүй. 6 дахь хэвлэл.
2. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Мөнгөнтулга.Э., ба бусад. 2018. Эрүүл мэнд. Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж. Улаанбаатар.
3. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Жаргал.Б., ба бусад. 2020. Суурь, бүрэн дунд боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж. Эрүүл мэндийн багшид зориулсан гарын авлага. VI-XII анги. Улаанбаатар.
4. Мөнгөнтулга.Э., Дарамбазар., Лхамсүрэн.В. 2019. Эрүүл мэнд Х. Ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангийн сурах бичиг. Улаанбаатар.
5. Мөнгөнтулга.Э., Болорцэцэг.Д., Жаргал.Б., ба бусад. 2019. Эрүүл мэнд IY. Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийн сурах бичиг. Улаанбаатар.
6. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Мөнгөнтулга.Э., ба бусад. 2016. "Амьдрах ухааны чадвар" багц гарын авлага. Улаанбаатар.
7. Мөнгөнтулга.Э., Байгалмаа,Ч., Дийдэрмаа.Ц., ба бусад 2018. Эрүүл мэндийн боловсрол эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр боловсруулагч, сурах бичиг зохиогч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын гарын авлага
8. Болорцэцэг.Д., Дийдэрмаа.Ц., Энхтогтох.А., ба бусад. 2012. Үе тэнгийн сургагчдын үйл ажиллагаа. Үе тэнгийн сургагчдад зориулсан гарын авлага

ЕБС-ийн Эрүүл мэнд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

Ч.Байгалмаа

МУБИС-ийн БСС-ийн багш

Ц.Дийдэрмаа

Нийслэлийн ЕБ-ын 47 дугаар сургуулийн багш

Хөндлөнгийн шинжээч:

Э.Мөнгөтулга

МУБИС-ийн МБУС-ийн багш

Техникийн редактор:

Д.Энхжаргал

Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн, магистр

Ш.Сувдмаа

Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа

Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

Цаасны хэмжээ:

A4

Хэвлэлийн хуудас:

3 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-мэйл: info@eec.mn Вэб: www.eec.mn